



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2023 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/220

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, Эмнэлгийн тусламжийн тухай хуулийн 4.1.5 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Үйлчлүүлэгчийг аюулгүй тээвэрлэх журам”-ыг нэгдүгээр, “Тээвэрлэлтийн зөвшөөрлийн хуудас”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Батлагдсан журмыг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын захирал, дарга нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газар /С.Сүнчин/-т даалгасугай.



САЙД

S. Chinzorig

С.ЧИНЗОРИГ

Эрүүл мэндийн сайдын 2023 оны
06 сарын 22 өдрийн 1/20 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙГ АЮУЛГҮЙ ТЭЭВЭРЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Үйлчлүүлэгчийг тээвэрлэх явцад аюулгүй байдлыг ханган тусламж, үйлчилгээг тасралтгүй үзүүлэх, үйлчлүүлэгчийг эрүүл мэндийн байгууллагад хүлээлгэн өгөхдөө эмнэлгийн мэргэжилтэн хооронд эрүүл мэндийн талаарх мэдээлэл дамжуулахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Эрүүл мэндийн байгууллага нь үйлчлүүлэгчийг аюулгүй тээвэрлэх, зөөвөрлөхөд шаардлагатай автомашин, эмнэлгийн зориулалттай зөөвөрлөх эмнэлгийн хэрэгсэл, тээвэрлэх явцад хэрэглэх хучлага бусад хэрэгслийн бэлэн байдлыг ханган ажиллана.
- 1.3. Үйлчлүүлэгчийг тээвэрлэх, эрүүл мэндийн байгууллагад хүлээлгэн өгөх хүртэлх бүхий л хугацаанд гадаад, дотоод орчин болон эмнэл зүйн шалтгаант эрсдэлийг бууруулж, аюулгүй байдлыг хангана.
- 1.4. Тээвэрлэлтийн үеийн эрсдэлийг тооцохдоо эмнэлзүйн эрсдэлийг үнэлэх Эрүүл мэндийн сайдын тушаал, Стандартчилалын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас батлан гаргасан “Унаж бэртэх эрсдэлийг үнэлэх түүнээс урьдчилан сэргийлэх арга” стандартын хавсралтад заасан эрсдэлийн үнэлгээний хуудсыг ашиглана.
- 1.5. Эмнэлзүйн эрсдэлийг үнэлэхгүйгээр биеийн байдал нэн хүнд үйлчлүүлэгчийг тээвэрлэхийг хориглоно.
- 1.6. Тээвэрлэх явцад замын эмнэлгүүдтэй холбоо тогтоож мэдээлэх, болзошгүй тохиолдолд тусламж авах нөхцөл бүрдүүлэх, шаардлагатай тохиолдолд тээвэрлэж буй багийн өмнөөс хүлээн авч буй эмнэлгийн тээвэрлэлтийн баг “угтаж” уулзаж тусламж, үйлчилгээг үзүүлж болно.
- 1.7. Энэхүү журмыг өмчийн бүх хэлбэрийн эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэгч эрүүл мэндийн байгууллага дагаж мөрдөнө.

Хоёр. Зорилго

2.1. Үйлчлүүлэгчид цаг алдалгүй, үр дүнтэй тусламж үйлчилгээг үзүүлэн амь насыг аврах, эрүүл мэндийг хамгаалах, тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг ханган эрсдэлийг бууруулан аюулгүй тээвэрлэх

Гурав. Тээвэрлэлтийн ангилал, төрөл

3.1. Үйлчлүүлэгчийг тээвэрлэх үйл ажиллагааг дараах байдлаар ангилна. Үүнд:

3.1.1. Эмнэлэг доторх тээвэрлэлт – Эмнэлгийн тасаг, нэгж хооронд тээвэрлэх;

3.1.2. Эмнэлгээс гаднах тээвэрлэлт – Өөр эмнэлэг, эрүүл мэндийн байгууллага болон бусад газарт тусламж, үйлчилгээ үзүүлэх, эмнэлгийн тусламжийн тасралтгүй байдлыг хангах, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хүргэх,

3.2. Үйлчлүүлэгчийн биеийн байдал, зам тээвэр, дэд бүтэц, цаг агаарын нөхцөлөөс шалтгаалан дараах төрлүүдээс сонгон эмнэлгийн гаднах тээвэрлэлтийг хийнэ. Үүнд:

3.2.1. Ойрын тээвэрлэлт – Тусламж, үйлчилгээ үзүүлэх газраас 75 км-ын дотор байршилд тээвэрлэх

3.2.2. Алсын тээвэрлэлт – Тусламж үзүүлсэн газраас 75 км-ээс дээш зайд үйлчлүүлэгчийг тээвэрлэх

3.3. Энэхүү журмын 3.1.2-д заасан тээвэрлэлтийг хийх бол дараах хэлбэрээс сонгоно. Үүнд:

3.3.1. Газраар тээвэрлэх:

3.3.1.1. Автомашинаар тээвэрлэх

3.3.1.2. Галт тэргээр тээвэрлэх

3.3.1.3. Усаар тээвэрлэх

3.3.2. Агаараар тээвэрлэх

4.2.2.1. Нисдэг тэргээр хийх тээвэрлэлт

4.2.2.2. Онгоцоор хийх тээвэрлэлт

Дөрөв. Тээвэрлэх үйл ажиллагаа

4.1. Эмнэлгийн доторх тээвэрлэлт:

4.1.1. *Тээвэрлэлтийн өмнөх бэлтгэл үйл явц*

4.1.1.1. Үйлчлүүлэгчийн биеийн байдал, тээвэрлэлтийн үеийн эрсдэлийг тооцон, тээвэрлэлтэд оролцох эмнэлгийн ажилтны тоо, хэвтээ болон суугаа тээвэрлэлт хийх зааварчилгааг эмчлэгч эмч өгнө. Дараах бэлтгэлийг хангасан байна. Үүнд:

- 4.1.1.1.1. Өвчтөний түүх, бичиг баримтыг авах;
- 4.1.1.1.2. Тэргэнцэр эсвэл зөөврийн ор, хучлага бусад зүйлсийг бэлдэх;
- 4.1.1.1.3. Хүчилтөрөгч – хүчилтөрөгчийн баллоны цэнэгийг шалгах, тээвэрлэх үед хүрэлцэх эсэхийг шалгах;
- 4.1.1.1.4. Хүчилтөрөгч өгөх хэрэгслүүд /хамрын ац гуурс, хавхлагагүй маск, хавхлагатай маск, хүүдийтэй маск, насанд тохирсон интубацийн гуурс/-ийг бэлдэх;
- 4.1.1.1.5. Ларингоскопи – зай нь байгаа эсэх, гэрэл нь асаж байгаа эсэхийг шалгах;
- 4.1.1.1.6. Нэмэлтээр уян зүүг авах;
- 4.1.1.1.7. Зөөврийн ламп- цэнэгтэй эсэх, тээвэрлэлтийн үед хүрэлцэх эсэх;
- 4.1.1.1.8. Зөөврийн монитор, пульс-оксиметр - цэнэгтэй эсэх, тээвэрлэлтийн үед хүрэлцэх эсэхийг шалгаж бэлдэнэ.

4.1.2. Тээвэрлэх үйл явц

- 4.1.2.1. Тээвэрлэлт хийх эмнэлгийн ажилтан үйлчлүүлэгч, түүний асран хамгаалагчид өөрийгөө танилцуулж, үйлдлийг тайлбарлана.
- 4.1.2.2. Үйлчлүүлэгчийг бүрэн хувцаслах боломжгүй үед хучлагатай тээвэрлэнэ.
- 4.1.2.3. Үйлчлүүлэгчийг тээвэрлэх явцад аюулгүй байдлыг ханган дараах үйлдлийг гүйцэтгэнэ. Үүнд:
 - 4.1.2.3.1. Хажуугийн хашлагыг өндөрсгөнө.
 - 4.1.2.3.2. Аюулгүйн бүс зүүнэ.
 - 4.1.2.3.3. Ухамсарт ухаантай үйлчлүүлэгчид гарыг хашлаганы дотор байлгахыг сануулна.
 - 4.1.2.3.4. Дуслын систем, байнгын катетр, хяналтын төхөөрөмжүүд болон урсгуур, бусад холболтууд аюулгүй байх, дусал тариа, дуслын систем болон биологийн шингэн цуглуулах савнууд тохиромжтой байрлалд байршуулна.
 - 4.1.2.3.5. Үйлчлүүлэгчийн толгой, гар, хөл хамгаалагдсан, хангалттай жийргэвчтэй, аль болох тухтай байрлуулна.
 - 4.1.2.3.6. Үйлчлүүлэгчийн хөл талаар түрүүлж явах бөгөөд үйлчлүүлэгчийн биеийн байдал хямрахаас сэргийлж огцом, хурдтай хөдөлгөөн хийхээс зайлсхийнэ.
 - 4.1.2.3.7. Тээвэрлэж буй ажилтан болзошгүй аюулаас сэргийлэн үйлчлүүлэгчийн толгойн хэсэгт байрлана. Хэрэв тээвэрлэхэд 2 ажилтан оролцож байгаа бол болзошгүй аюулаас сэргийлэн хоёр дахь нь үйлчлүүлэгчийн орны хөлд байрлана.

- 4.1.2.3.8. Зөөвөрлөх хэрэгслээр хаалга түлхэж онгойлгохыг хориглоно.
- 4.1.2.3.9. Үйлчлүүлэгчийг цахилгаан шатанд толгой талаар нь эхэлж оруулна.
- 4.1.2.3.10. Тээвэрлэх явцад үйлчлүүлэгчийг хараа хяналтгүй үлдээхийг хориглоно.
- 4.1.2.3.11. Тээвэрлэлт зогсох үед зөөвөрлөх хэрэгслийн дугуйг түгжинэ.
- 4.1.2.3.12. Зайлшгүй шаардлагатай үйлчлүүлэгчид:
 - 4.1.2.3.12.1. Хүчилтөрөгчийн эмчилгээг үргэлжлүүлэн тунг тохируулна.
 - 4.1.2.3.12.2. Зөөврийн мониторт холбож, тээвэрлэх үе дэх амин үзүүлэлтийг хянана.
 - 4.1.2.3.12.3. Цусны эргэлтийн дэмжлэгтэй бол зөөврийн тарилгын пампыг бэлдэн тээвэрлэлтийн явцад тариаг таслахгүй байна.

4.2. Эмнэлгийн гаднах тээвэрлэлт

- 4.2.1. Түргэн тусламжийн автомашин, галт тэрэг, онгоц, нисдэг тэргээр сургагдсан эмнэлгийн мэргэжилтэн, баг үйлчлүүлэгчийг тээвэрлэн хүргэнэ.
- 4.2.2. *Тээвэрлэх шийдвэр гаргах:*
 - 4.2.2.1. Үйлчлүүлэгчийн биеийн байдлыг үнэлнэ.
 - 4.2.2.2. Оношилгоо, эмчилгээний хэрэгцээнд үндэслэн тээвэрлэх асуудлыг шийдвэрлэнэ.
 - 4.2.2.3. Тээвэрлэх шийдвэрийг цаашид үйлчлүүлэгчид үзүүлэх тусламж тухайн эмнэлгийн нөөцөөс давах эрсдэлтэй, тусламж үйлчилгээнд нарийн мэргэжлийн эмч, баг шаардлагатай зэрэгт үндэслэн тээвэрлэн хүргэх гэж буй эмнэлгийн холбогдох удирдлага, зөвлөх эмч, эмчлэгч эмчтэй ярилцаж, гаргана.
 - 4.2.2.4. Биеийн байдал нэн хүнд болон хүнд үйлчлүүлэгчийг эмнэлэг хооронд тээвэрлэлтийг амь тэнссэн үеийн тусламж, үйлчилгээ үзүүлэх чадвартай мэргэшсэн тээвэрлэлтийн баг, сургагдсан эмнэлгийн мэргэжилтэнг томилно.
- 4.2.3. *Тээвэрлэлтийн өмнөх харилцаа, холбоо тогтоох*
 - 4.2.3.1. Үйлчлүүлэгчийг эмнэлэг хооронд тээвэрлэхийн өмнө хүлээн авах эмнэлэгт урьдчилан заавал мэдэгдэн хүргэх эмнэлэг болон тээвэрлэх гэж буй эмнэлэг хооронд байнгын холбоо харилцаатай байна.

- 4.2.3.2. Эмнэлгээс эмнэлэгт хүрэх хугацаа, гарч болох эрсдэлийг тооцоолно.
- 4.2.3.3. Эмнэлгийн лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлэгч эмнэлэг болон бусад эмнэлэг болон эмнэлгийн мэргэжилтэн хооронд зөвлөгөө авах, үйлчлүүлэгчийн талаар аливаа харилцаа холбоо тогтоохдоо ISBAR зөвлөмжийг ашиглана.
- 4.2.3.4. ISBAR зөвлөмжийг сувилагч-сувилагч, эмч-сувилагч, сувилагч-эмч, эмч-эмч, эмч-зөвлөх эмч хоорондын харилцаанд ашиглана. Үүнд:
 - 4.2.3.4.1. Identify- Танилцуулах
 - 4.2.3.4.2. Situation-Нөхцөл байдлыг танилцуулах
 - 4.2.3.4.3. Background – Өвчний түүхийг товч дурдах
 - 4.2.3.4.4. Assessment – Үйлчлүүлэгчийн үнэлгээ, одоогийн байдал
 - 4.2.3.4.5. Recommendation- Ямар тусламж хүсэж буйгаа хэлэх
- 4.2.4. *Биеийн байдлыг тогтворжуулах, тээвэрлэх*
 - 4.2.4.1. Үйлчлүүлэгчийг тээвэрлэхийн өмнө биеийн байдлыг тогтворжуулж тухайн эмнэлэгт хийх боломжтой үзлэг, шинжилгээ, эмчилгээг хийнэ.
 - 4.2.4.2. Үйлчлүүлэгчин амин үзүүлэлтүүдийг тээвэрлэлтийн өмнө монитороор хянах, захын ба төвийн венийн гуурстай бол хэвийн эсэх, физиологийн байдал тогтвортой эсэх, одоогийн эмнэл зүйн байдлыг заавал үнэлнэ.
 - 4.2.4.3. Тээвэрлэлтийн өмнө хийгдсэн бүх шинжилгээг хуулах эсхүл хэвлэн авсан байна.
 - 4.2.4.4. Үйлчлүүлэгчийн биеийн байдлыг тогтворжуулсны дараа тээвэрлэх боломжит арга, хэлбэрийг сонгоно.

Тав. Үйлчлүүлэгч тээвэрлэх автомашин болон эмнэлгийн зөөврийн хэрэгсэлд тавигдах шаардлага

- 5.1. *Эмнэлгийн зориулалтай үйлчлүүлэгч зөөвөрлөх хэрэгсэл буюу тэргэнцэр, зөөврийн оронд тавигдах шаардлага:*
 - 5.1.1. Дугуй түгжигддэг эргэлт хийдэг байх;
 - 5.1.2. Өндрийг тохируулдаг байх;
 - 5.1.3. Аюулгүйн бүстэй байх;
 - 5.1.4. Хажуугийн хашлага эвхэгддэг, хашлагыг өндөрсгөх, буулгах боломжтой байх;
 - 5.1.5. Дуслын системийн хөл байршуулах, хялбар шилжүүлэх боломжтой байх;
 - 5.1.6. Хүчилтөрөгчийн бортого, хяналтын төхөөрөмжийг зөөвөрлөх боломжтой байх;

5.1.7. Үйлчлүүлэгчийг тохиромжтой байршилд байрлуулах боломжтой байх;

5.1.8. Зөөврийн орон дээрх зөөлөвч хөдөлгөөнгүй, халдваргүйжүүлэх боломжтой байх,

5.2. *Үйлчлүүлэгч тээвэрлэх автомашинд тавигдах шаардлага:*

5.2.1. Түргэн тусламжийн төвийн бүтэц үйл ажиллагааны стандарт MNS 6717:2018 стандартын В хавсралтад заасан шаардлагыг хангасан байна.

Зургаа. Нэн хүнд үйлчлүүлэгчийг тээвэрлэх явцад анхаарах асуудал

6.1. Нэн хүнд үйлчлүүлэгчийг тээвэрлэх явцад гарах физиологийн нөлөөг багасгахын тулд дараах зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

Газраар тээвэрлэлт	Агаараар тээвэрлэлт
<ul style="list-style-type: none">• Тээвэрлэлтийн явцад үйлчлүүлэгч хүндрэх, физиологийн өөрчлөлт гарахаас сэргийлж сэхээн амьдруулалтыг зохистой түвшинд үзүүлж тээвэрлэхийн өмнө сайн тогтворжуулах• Толгой, цээжин биеийг 15 хэм өргөж байрлуулах нь гавлын дотоод даралт нэмэгдүүлэх инерцийн хүчний нөлөөг багасгадаг• Хурдатгалын нөлөөнөөс хамгаалах үүднээс хөлийг өндөрлөх• Үйлчлүүлэгчид интубаци тавьж тээвэрлэх нь аспирацийн эрсдэлийг бууруулна. Интубаци заалтгүй өвчтөнд бөөлжилтийн эсрэг эм өгөх.• Тээвэрлэлтийн явцад биеийн температурыг тогтмол хянах• Биеийн дарагдах хэсгүүдийг шалгах	<ul style="list-style-type: none">• Пневмоторакстай бол тээвэрлэхийн өмнө соруулга хийх• Гипокситой үйлчлүүлэгчид нэмэлтээр хүчилтөрөгч өгөх эсхүл нам нислэг үйлдэх• Хэрэв үйлчлүүлэгч хүндрэх эрсдэлтэй бол тээвэрлэлтийн өмнө интубаци тавих• Хэрэв интубацийн гуурсны жийргийн дарагдалт нэмэгдэх эрсдэлтэй бол жийргийг натри хлоридийн 0.9%-ийн уусмалаар дүүргэх• Үйлчлүүлэгчийн биеийн температур болон дарагдал үүсэх газруудыг тогтмол хянах

6.2. Нэн хүнд буюу амь тэнссэн үйлчлүүлэгчийг тээвэрлэх үед гарч болох хүндрэлээс сэргийлж дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

6.2.1. Үйлчлүүлэгчээс шалтгаалах - өндөр РЕЕР шаардлагатай, мэс заслын дараах, хүнд гэмтэлтэй үйлчлүүлэгч, олон төрлийн эмийн дэмжлэг, тарилга шаардлагатай үйлчлүүлэгч гэх мэт

6.2.2. Эмнэлэг, зохион байгуулалттай холбоотой - Тээвэрлэлтийн баг туршлагагүй, бэлтгэгдээгүй, хүлээн авах эмнэлэгтэй харилцаа тогтоогоогүй, үйлчлүүлэгчийн биеийн байдлыг гүйцэд үнэлээгүй, тогтворгүйжүүлэлт сайн хийгээгүй, тээвэрлэлтийн явцын эмчилгээ тасалдуулсан гэх мэт

6.2.3. Техникийн хамааралтай- Машин эвдрэх, хүчилтөрөгчийн нөөц дуусах, хяналтын монитор доголдох, шахуурга доголдох, бензин дуусах гэх мэт

6.2.4. Цаг уурын таагүй нөхцөл, байгалийн гамшигт үзэгдэл болох гэх мэт.

Долоо. Баримтжуулалт

7.1. Үйлчлүүлэгчийг тээвэрлэхийн өмнө үйлчлүүлэгч болон тэдний ар гэр, асран хамгаалагчдад тээвэрлэлт, гарч болох хүндрэл эрсдэлийн тухай мэдээлэл өгч, энэхүү журмын хавсралтад заасан тээвэрлэх хийх зөвшөөрлийн хуудсанд гарын үсэг зуруулна.

7.2. Үйлчлүүлэгчийг тээвэрлэхийн өмнөх аюулгүй байдлын хангах хяналтыг эрүүл мэндийн байгууллага бүр өөрийн тусламж, үйлчилгээний онцлогийг тусгасан хяналтын хуудас боловсруулан хийнэ.

7.3. Үйлчлүүлэгчийг эмнэлэг хооронд тээвэрлэхдээ үйлчлүүлэгчийн биеийн байдал, онош, хийгдсэн оношилгоо, эмчилгээний талаар хүлээн авах эмнэлгийн эмчид эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан “Эмнэлэгт өвчтөн илгээх хуудас-13А” маягтыг хөтөлж илгээнэ.

7.4. Үйлчлүүлэгчийг дараагийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эмчид хүлээлгэн өгөхдөө тээвэрлэлтийн үеэр биеийн байдалд гарсан өөрчлөлт, хэрэглэсэн эм тариа, хоол хүнсний талаарх мэдээллийг өгнө.

7.5. Нярай тээвэрлэсэн тохиолдолд Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан “Нярайн шилжүүлгийн маягт”-ыг бөглөнө.

Найм. Үүрэг, хариуцлага

8.1. Эрүүл мэндийн байгууллага нь үйлчлүүлэгчийг аюулгүй тээвэрлэх сургалтад эрүүл мэндийн ажилтанг хамруулсан байна.

8.2. Тээвэрлэлт хийх эмч, эрүүл мэндийн ажилтанг зохих ёсны даатгалд хамруулж ажилчдыг хувийн хамгаалах хэрэгсэл, зааварчилгаагаар хангана.

8.3. Эрүүл мэндийн байгууллагын дарга, эмчилгээ эрхэлсэн орлогч дарга нь холбогдох эмнэлэг, тасаг, нэгжид үйлчлүүлэгчийг тээвэрлэх үйл ажиллагааг журмын дагуу гүйцэтгэх нөхцөлөөр ханган ажиллана.

8.4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын алба /баг/ нь журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

8.5. Эрүүл мэндийн байгууллага нь үйлчлүүлэгчийг хурдан шуурхай, аюулгүй тээвэрлэх бэлэн байдлыг хангасан байна. Үүнд:

- 8.5.1. Эмнэлэг бүр тусламж, үйлчилгээний онцлогийг тусгасан үйлчлүүлэгчийг тээвэрлэх журамтай байх бөгөөд тус журамд эрүүл мэндийн ажилтанд өгөх зааварчилгаа, харилцаа, үг хэллэг, кодын систем, өнгөний илэрхийлэл ойлгомжтой, тодорхой тусгагдсан байна.
- 8.5.2. Үйлчлүүлэгчийг шилжүүлэх тохиолдолд мэдээлэл, харилцаа холбооны бэлэн байдлыг хангасан байна.
- 8.5.3. Эрүүл мэндийн байгууллага нь тээвэрлэлтийн явцад эмнэлгийн тусламж үйлчилгээ, тээвэрлэлтийн болон мэдээлэл, харилцаа холбоотой тохиолдол илэрсэн үед цаг алдалгүй мэдээлэх, хариу арга хэмжээ авах тогтолцоотой байна.
- 8.5.4. Тээвэрлэлтийн багийн үйл ажиллагаа, тоног төхөөрөмжтэй хамаатай ноцтой тохиолдлоос сэргийлж, тогтмол эрсдэлийн үнэлгээг хийж, үр дүнг тооцно.
- 8.5.5. Оношилгоо, эмчилгээ хийх тоног төхөөрөмжгүй, шаардлагатай эмнэлгийн мэргэжилтэнгүй, тусламж, үйлчилгээг аюулгүй, үр дүнтэй гүйцэтгэх нөхцөл бүрдээгүй эрүүл мэндийн байгууллага руу үйлчлүүлэгчийг тээвэрлэхийг хориглоно.

Ес. Хяналт

9.1. Үйлчлүүлэгчийн эмнэл зүйн хяналт:

- 9.1.1. Цусны эргэлт - Судасны цохилт тэмтрэх, артерийн даралт хэмжих, захын цусны урсгалыг үнэлэх замаар цус эргэлтийг тодорхой давтамжтайгаар хянаж бүртгэнэ.
- 9.1.2. Амьсгал - Амьсгалын тоог тодорхой давтамжтайгаар үнэлж, бүртгэнэ.
- 9.1.3. Хүчилтөрөгчөөр хангах - Үйлчлүүлэгчийн хүчилтөрөгчийн ханамжийг ойр ойрхон, эмнэл зүйн хувьд давтамжтай ажиглах болон пульс оксиметрийн тусламжтайгаар үнэлж бүртгэнэ.
- 9.1.4. Комын Глазго үнэлгээгээр ухамсрын түвшин болон хүүхэн харааны урвалыг үнэлнэ.
- 9.1.5. Өвдөлтийн оноо - Үйлчлүүлэгчийн өвдөлтийг өвдөлтийн оноогоор тогтмол үнэлж, шаардлагатай тохиолдолд зохих эмчилгээг хийнэ.
- 9.1.6. Үйлчлүүлэгчийн тав тухтай байдал - Үйлчлүүлэгчийг аль болох дуу чимээ, доргионоос хамгаалсан орчны тайван байдалд байлгана.

9.2. Тоног төхөөрөмжийн хяналт:

- 9.2.1. Пульсоксиметр ба амьсгалаар ялгарах нүүрсхүчлийн хий /капнографи/- Биеийн байдал хүнд үйлчлүүлэгч бүрийг тээвэрлэх явцад пульсоксиметр ашиглана.

Зохиомол амьсгалуулалт хийлгэж буй бүх үйлчлүүлэгчийн (жишээлбэл: цагаан мөгөөрсөн хоолойн гуурс эсвэл төвөнхийн дээрх гуурс) амьсгалаар ялгарах нүүрсхүчлийн хийг хэмжинэ.

9.2.2. Амьсгалын хүрээ, гуурсны холболт салах, хүрээний даралт өндөр байх, мөн амьсгалуулалт амжилтгүй болох үед дуугарах дохиоллыг хянана. Автомат амьсгалын аппаратыг ашиглах үед амьсгалын систем дэх даралт багасах эвсэл ихсэх үед цаг алдалгүй дохиог өгч анхааруулах төхөөрөмж тасралтгүй ажиллаж байх ёстой.

9.2.3. Зүрхний ажиллагааг хянах - Хүнд үйлчлүүлэгчийг тээвэрлэх үед зүрхний цахилгаан бичлэгийг дэлгэцээр хянах монитормыг ашиглана.

9.2.4. Физиологийн даралт – Артерийн даралтыг инвазив эсвэл инвазив бус төхөөрөмжийг ашиглан хэмжинэ. Эмнэл зүйн заалттай бол тээвэрлэгдэж буй хүнд үйлчлүүлэгчдийн бусад даралтуудыг хэмжих боломжтой байх

9.3. Бусад тоног төхөөрөмж:

9.3.1. Эмнэлзүйн заалттай, сургагдсан эмнэлгийн мэргэжилтэн байгаа тохиолдолд зөөврийн хэт авиан шинжилгээний төхөөрөмжийг бэлэн байлгана.

9.3.2. Тоног төхөөрөмжийн дохиолол - Тоног төхөөрөмжийн дуу болон дүрсэн дохиоллоор илгээсэн анхааруулгын дагуу нягтална.

Арав. Сургалт

10.1. Үйлчлүүлэгчийг тээвэрлэх ажилтанг зохих сургалтад хамруулж, бие даан тээвэрлэлт хийхээс өмнө сургагдсан ажилтны хяналтад тээвэрлэлтийг хийлгэнэ.

10.2. Сургалтын хөтөлбөрт тээвэрлэхийн өмнө, тээвэрлэх явцад хэрэгжүүлэх үйл ажиллагаа, гарч болох эрсдэлийн үед авах хариу арга хэмжээ, үйлчлүүлэгчийн үнэлгээ, эмчилгээ, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, үйлчилгээнд тавигдах шаардлага, үйлчлүүлэгчийн аюулгүй байдал, халдварын сэргийлэлт, хяналт, эмнэлгийн зөөврийн хэрэгсэл болон автомашинд суурилагдсан тоног төхөөрөмжийг ажиллуулах, олон хүнийг хамарсан осол, хими, биологи, цацрагийн аюул, хөдөлмөрийн эрүүл ахуйн талаар тусгасан байна.

10.3. Шинээр тоног төхөөрөмж, эмнэлгийн хэрэгслээр хангагдсан тохиолдолд сургалтыг тухай бүр нь зохион байгуулна.

10.4. Эрүүл мэндийн байгууллага нь үйлчлүүлэгчийг аюулгүй тээвэрлэх сургалтыг жилдээ нэгээс доошгүй удаа зохион байгуулна.

Эрүүл мэндийн сайдын 2023 оны
06 сарын 22 өдрийн 140 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

Тээвэрлэлтийн зөвшөөрлийн хуудас

Үйлчлүүлэгчийн нэр /эцэг, эх, асран хамгаалагчийн нэр/ хүйс огноо	нас.....
1. Тээвэрлэх шалтгаан:	
2. Үйлчлүүлэгчийн биеийн байдал (Дараахын аль нэгийг сонгох):	
<input type="checkbox"/> Үйлчлүүлэгчийн биеийн байдал тогтвортой – Эрхтэн системийн дутагдалгүй	
<input type="checkbox"/> Үйлчлүүлэгчийн биеийн байдлыг тогтворжуулсан. Яаралтай тусламж үзүүлж биеийн байдлыг тогтворжуулсан.	
Тээвэрлэх үед гарч болох эрсдэл:	
<input type="checkbox"/> Үйлчлүүлэгчийн биеийн байдал тогтворгүй: Яаралтай тусламж үзүүлсэн боловч биеийн байдал тогтворжоогүй	
3. Хүлээн авах эмнэлэг:	
<input type="checkbox"/> Хүлээн авах эмнэлэгийн эмчтэй холбогдож зөвлөгөө авсан, үйлчлүүлэгчийг хүлээн авахыг зөвшөөрсөн.	
Зөвшөөрсөн эмчийн нэр: Огноо:Цаг:	
<input type="checkbox"/> Тээвэрлэх замд байрлах авах эмнэлэгтэй холбоо тогтоосон үйлчлүүлэгчид тусламж үзүүлэх боломжтой, хүлээн авахыг зөвшөөрсөн. / шаардлагатай үед/	
Хүлээн авах эмнэлэг:..... Хүлээн авах тасаг:	
Огноо Цаг:	
4. Шаардлагатай баримт бичиг:	
Хүлээн авах эмнэлэгт шаардлагатай баримт бичгийг хүлээлгэж өгөх:	
<input type="checkbox"/> Эмчийн хүсэлт <input type="checkbox"/> Яаралтай тусламжийн хуудас	
<input type="checkbox"/> Хийгдсэн шинжилгээ <input type="checkbox"/> Оношилгооны дүгнэлт <input type="checkbox"/> Сувилахуйн хуудас <input type="checkbox"/> Бусад	
5. Гэр бүлийнхэнд өгсөн мэдээлэл:	
<input type="checkbox"/> Үйлчлүүлэгчийн эд зүйлсийг хүлээлгэн өгсөн <input type="checkbox"/> Тээвэрлэлтийн үед үйлчлүүлэгчийн ар гэрийнхэн хамт байх <input type="checkbox"/> Тээвэрлэн хүргэх эмнэлэг, тасгийн мэдээлэл	
6. Тээвэрлэлтийг зөвшөөрөх/ татгалзсан/ асуулт:	
Үйлчлүүлэгчид шаардлагатай эмчилгээ, оношилгоо хийх зорилгоор тээвэрлэж байгааг ойлгож байна. Тээвэрлэлтийн явцад гарч болох эрсдэл, хүндрэлийг эмч надад тайлбарласан.	
Эмчээс асуух асуулт:	

Эмчийн хариулт:

Гарын үсэг: 1. Үйлчлүүлэгчийн асран хамгаалагч / /
Гарын үсэг нэр

2. Үйлчлүүлэгчийн асран хамгаалагч / /
Гарын үсэг нэр

Нэр, гарын үсэг:

Эмч:

Сувилагч: